

ТАВ. УДИРДЛАГЫН БҮХ ТҮВШИНД НЭГДСЭН БОДЛОГООР БАГШИЙН ТАСРАЛТГҮЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ, БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

5.1. МУБИС, МУИС, ШУТИС-ийн багш нартай туршлага солилцох уулзалтыг зохион байгуулах

- Их дээд сургуулийн мэргэжлийн бус ангийн оюутнуудад заагдаж буй “Монголын түүх соёл, ёс заншил” хичээлийн хүрээнд оюутан солилцох сургалтыг зохион байгуулж уг үйл ажиллагаанд АШУҮИС, МУБИС, ХСИС-ууд оролцсон. Энэхүү сургалтын зорилго нь тухайн сургалтыг дэмжин оролцож буй сургуулийн оюутнууд хооронд соёлын солилцоо өрнүүлэх, заах арга зүйн туршлага солилцох, мөн багш оюутнуудын хамтын ажиллагааг дэмжих зорилготой. 2018
- МУИС-ин багш нартай хамтран жил бүр оюутны бакалаврын дипломны ажлыг удирдаж, судалгааны ажлыг хамтран хэрэгжүүлж байна.
- ШУТСангийн захиалгат төслийн ажлын хүрээнд МУИС-ийн багш нартай хамтран судалгааны ажлын баг болон хамтран ажиллаж байна.
- МУИС болон Оксфордын их сургуулийн хамтран зохион байгуулсан “Social science research training” summer school сургалтанд багш нар хамрагдсан. 2022
- Нийгмийн хөгжил хичээлийн хүрээнд Хөгжлийн хандлагатай нийгмийн ажил сэдвээр МУИС-ийн Социологи Нийгмийн ажлын тэнхимийн багш Б.Нандинцэцэг нар уригдаж дадлага болон семинарыг хичээлд оролсон. 2022
- МУИС-ийн Бизнесийн сургуулиас зохион байгуулах “Хүнс Үйлдвэрлэлийн Бизнес Загварыг Хөгжүүлэх Боломж, Туршлага” сэдэвт чуулга уулзалтад ШТСТ-ийн багш нар оролцсон. 2022
- “Хүнсний хор судлал” хичээлийн хүрээнд ХААИС-ын хүнсний химич, доктор С.Отгонпүрэв багшийг урьж “Хүнс бохирдуулах ургамлын гаралтай хор, байгалын гаралтай хорууд” сэдвээр ЭМХЗ 4-р дамжааны оюутнуудад сургалт зохион байгуулсан. 2022
- ХААИС-ын МЭУ-ны доктор Д.Дэлгэрмөрөн багшийг урьж “Хоол хүнсэн дэх эмийн бодисын үлдэгдэл” сэдвээр ЭМХЗ 4-р дамжааны оюутнуудад сургалт зохион байгуулсан. 2022
- Жил бүр зохиогддог их сургуулиудын консерциумын шатар болон гар бөмбөгийн тэмцээнд Б.Билэгт, Д.Ням-Осор багш нар АШУҮИС-ийн багш нартай хамтран МУИС, ХААИС, ШУТИС, СУИС, Батлан хамгаалах, Хил хамгаалах зэрэг их сургуулийн багш нартай хамт оролцдог.

5.2. Тэнхим, профессорын баг хамт олны хөгжлийг дэмжих зардлыг бий болгох, төлөвлөгөөнд тусгаж ажиллах

Санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор багш нар болон тэнхим багц цагийн сургалтыг зохион байгуулдаг бөгөөд давхар НЭМ-ийн хүрээлэнгээр дамжуулан орлого нэмэгдүүлэх боломж нээгдсэн. Мөн НЭМС-ийн “Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх” зорилтын хүрээнд төсөл болон лабораторийн үйл ажиллагаас төсөв бүрдүүлж ажилладаг. Үүнд:

1. 2018 онд үндсэн бус үйл ажиллагаанаас нийт 178,800,073₮;
2. 2019 онд 43,449,020₮;
3. 2020 онд 100,212,806₮;
4. 2021 онд 124,000,000₮;

5. 2022 онд 84,000,000₮.

5.3. Багш нарт зориулсан амрах өрөөг бий болгож тохижуулах

Олон улсын жишигт нийцэхүйц судалгааны орчин нөхцөлийг бүрдүүлсэн, үндэсний тэргүүлэгч судалгааны их сургууль болох АШУҮИС-ийн хөгжлийн бодлогод уялдуулан, НЭМС-ийн багшшийн хөгжлийн дэд хөтөлбөрийн 5.3-т заасны дагуу багш нарын ая тухтай байдлыг хангах хичээлийн өрөө болон ажлын өрөөг үе шаттайгаар сайжруулж байна. Багш нарын чөлөөт цагаараа амрах өрөөг бий болгож, тохижуулах зорилт тавин ажиллаж байна.

5.4. Багшийн нийгмийн хамгааллыг дэмжихэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулах

Багшийн хөгжлийн хөтөлбөрийн 3.5.8-д Багш нарын нийгмийн хамгааллыг дэмжихэд чиглэсэн ажлуудыг зохион байгуулах, НЭМС-ийн 5.4-д мөн заасны дагуу багш нарынхаа АШУҮИС-ийн үйлдвэрчний эвлэлд багш нар гишүүнээр орж хамтран ажилладаг. Мөн нийгмийн хамгааллын чиглэлээр гадны байгууллагуудтай хамтран багш нарт оюуны өмчийг хэрхэн хамгаалж бүртгүүлэх, санхүүгээ хэрхэн зөв зохицуулах чиглэлээр сургалтыг зохион байгуулдаг.

5.5. Багш нарыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт 2 жил тутам хамруулах (ЭМС, НХХС-ын 2014 оны 340 тоот тушаал)

НЭМС-ийн Багшийн хөгжлийн дэд хөтөлбөрийн 5.5-д Багш нарыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт 2 жил тутам хамруулах зорилт дэвшүүлсэн бөгөөд 2023 оны 04 сард НЭМС-ийн агш нарыг бүгдийг нь эрүүл мэндийн үзлэгт хамруулахаар төлөвлөгөөнд оруулж МЯЭ дээр цаг бүртгүүлсэн.

5.6. Жилийн ажлын дүнгээр шилдгээр шалгарсан багш болон тэнхимийн шагналын мөнгөн санг нэмэгдүүлэх

АШУҮИС-ийн “Оны шилдэг ажилтан, хамт олон шалгаруулах журам”-ын дагуу НЭМС-ийн оны шилдэг багш, тэнхимийг жилд нэг удаа шалгаруулж урамшуулал олгодог. НЭМС-ийн бүх багш, ажилтнуудын хурлыг 11-р сард багтаан зохион байгуулж, захирал Д.Даваалхам болон 6 тэнхимийн эрхлэгчид оны ажлын тайлангаа танилцуулдаг. 2015 онд шилдгүүдэд олгодог мөнгөн дүн 640.000 төгрөг байсныг жил бүр бага багаар нэмэгдүүлж 2022 онд 2.000.000 төгрөг болгосон.